



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠓ сарын ᠕ өдөр

Дугаар ᠕/᠒᠐

Улаанбаатар хот

Багануур дүүргийн Биеийн тамир,
спортын хорооны эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 02 дугаар сарын 04-ний 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,995,970.00 (гурван сая есөн зуун ерэн таван мянга есөн зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо (Г.Сүхбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 3 нэр төрлийн 1,930,000.00 (нэг сая есөн зуун гучин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 6 нэр төрлийн 2,065,970.00 (хоёр сая жаран таван мянга есөн зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо (Г.Сүхбаатар)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА

... שטענדיג ווערן זיי געטראפן אין אים, און ווערן
 געטראפן אין אים, און ווערן געטראפן אין אים.

... שטענדיג ווערן זיי געטראפן אין אים, און ווערן
 געטראפן אין אים, און ווערן געטראפן אין אים.



Нийслэлийн Өмчийн харилцааны
дугаарын 2025 оны дугаар сарын 1-
өдрийн АИР дугаар тушаалын х

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо

[illegible]